



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 01


Улаанбаатар хот

Дэд хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.9, 24.10 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Хүний эрхийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ёндонгийн Отгонбаярыг сонгосугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн


Гишүүд:

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Д.Мөнх-Эрдэнэ - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга
Ө.Жамбалсүрэн - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч
Ж.Нарантуяа - Хуульч
Н.Энхтуяа - Хуульч
Б.Баасандорж - Хууль зүйн байнгын хорооны Ахлах зөвлөх
Б.Батсэлэнгэ - Хууль зүйн байнгын хорооны зөвлөх
Б.Хонгорзул - Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ

УХА0316



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Нямдорж - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

З.Баянсэлэнгэ - Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд - Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн
Р.Гончигдорж - Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн
Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Д.Дорлигжав - Хууль зүйн сайд
Ч.Өнөрбаяр - Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх
Т.Бат-Өлзий - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга
Н.Анхбаяр - Гадаад хэргийн яамны Хүний эрхийн хэлтсийн дарга
Н.Лувсанжав - "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" НҮБХХ-ийн төслийн зөвлөх

А.Энхмаа

-Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн


Х.Номингэрэл

-Судлаач

Б.Баасандорж
Б.Батсэлэнгэ
Б.Хонгорзул

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх
-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх
-Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д. ГАНБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын дэд хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын даргын 2015 оны 53 дугаар захирамжийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын даргын 2015 оны 53 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн

Нарийн бичгийн дарга:

Б.Баасандорж -Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх

Ажлын дэд хэсгийн гишүүд:

Д.Дорлигжав -Хууль зүйн сайд
Б.Батцэрэн -Улсын дээд шүүхийн шүүгч
М.Энх-Амгалан -Улсын ерөнхий прокурор
Г.Эрдэнэбат -Улсын ерөнхий прокурорын орлогч
Ж.Баярцэцэг -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Т.Бат-Өлзий -Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

Т.Ганбаатар -Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга


О.Батбилэг -Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн хэлтсийн дарга

Д.Эрдэнэбаатар -Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга

Э.Амарбат -Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Мөрдөх албаны дарга

Б.Батаа	-Хүний эрхийн Үндэсний комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга
Д.Батсүх	-Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгч
Л.Данзанноров	-Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн
Г.Оюунболд	-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
Б.Гантуяа	-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн
Д.Баярсайхан	-МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
Ж.Эрдэнэбулган	-МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш
Ж.Болдбаатар	-Хууль сахиулахын их сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга
Ц.Хүрэлбаатар	-Тагнуулын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга
Д.Баянжаргал	-Нийслэлийн прокурорын орлогч
Б.Төмөрбат	-Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга
Ц.Гантулга	-Хууль сахиулахын их сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
Д.Энхжаргал	-Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал
Г.Гантөмөр	-Отгонтэнгэр их сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, доктор профессор
Б.Батсэлэнгэ Г.Нямдэлгэр Ч.Батбямба Б.Хонгорзул	-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны референт -Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 05/05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн
С.Бямбацогт - Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ч.Өнөрбаяр - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх

М.Батсуурь - Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүн

Ц.Цогт - Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

А.Сарангэрэл - Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 20 дугаар шүүхийн шүүгч

Ц.Ариунжаргал - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн

Д.Сүнжид

П.Одгэрэл

Д.Ганзориг

Б.Баасандорж

Ч.Ариунхур

Б.Батсэлэнгэ

Ж.Бямбадулам

Б.Хонгорзул

Б.Төрболд

-Доктор, нийтийн эрх зүйн судлаач

-Доктор, нийтийн эрх зүйн судлаач

-Нийтийн эрх зүйн судлаач

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх



-Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх

-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

-Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөх

-Хууль зүйн байнгын хорооны референт

-Төрийн байгуулалтын байнгын хорооны референт





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүдийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Арвинг нэмсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ